



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 02 дугаар сарын 27

Дугаар 3

Улаанбаатар хот

### III ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хуралдаан 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 17.00 цагт Төрийн ордон дахь "Сүхбаатар танхим"-д <sup>94.7</sup> хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

### ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Зудын нөхцөл байдлын талаар

Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга,  
хурандаа Т.Баярхүү

2. Бусад

## ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

***Нэг. Сангийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Энхбаяр, ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга, Улсын онцгой комиссын гишүүн Б.Ганбат, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул нарт:***

1.1. Зудын нөхцөлд шилжиж хаваржилт хүндэрсэн сумдын малчин өрхүүдэд хүнсний тусламж үзүүлэхэд шаардлагатай хөрөнгийн асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;

1.2. Сумдын засаг даргын Тамгын газрын автомашинууд эвдэрсэн, ашиглалтын хугацаа дууссан зэрэг шалтгааны улмаас иргэдэд төрийн болон бусад үйлчилгээг хүргүүлэхэд хүндрэл учирч байгаа тул иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээг шуурхай хүргэх зорилгоор сумдад туулах чадвар сайтай автомашин худалдан авч олгох асуудлыг нэн даруй Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;

***Хоёр. Батлан хамгаалахын сайд, Улсын онцгой комиссын орлогч дарга Г.Сайханбаяр, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, хошууч генерал С.Ганбямба, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Х.Лхагвасүрэн, Улсын онцгой комиссын Шуурхай штабын дарга, бригадын генерал Б.Ууганбаяр нарт:***

2.1. Цасанд боогдсон зам, давааг чөлөөлөх, айл өрхүүдэд хүнс, түлээ түлш, малын тэжээл хүргэх ажлыг аймаг, сумдын Онцгой комисстой хамтран өргөн хүрээнд зохион байгуулах, уг ажилд шаардлагатай хүн, хүч хэрэгслийг нэмэлтээр дайчлан гаргах;

2.2. Хил орчмын иргэдэд тусламж үзүүлэх, эрэн хайх аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, улсын нөөцийн бараа материал хүргэхэд машин техник, хүн хүч гаргах;

***Гурав. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Х.Болорчулуун нарт:***

3.1. Зудад нэрвэгдэж амьжиргааны эх үүсвэрээ алдаж, малгүй болсон малчдын судалгааг нарийвчлан гаргаж, эрсдэлд орсон малчин айл өрхүүдэд чиглэсэн нийгмийн хамгаалал, халамжийн бодлогыг хэрэгжүүлэх, малжуулах болон бусад төсөл хөтөлбөрүүдэд хамруулах, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг Улсын онцгой комисс, Засгийн газарт тухай бүр танилцуулах;

**Дөрөв. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Х.Болорчулуун, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Т.Сүхболд, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:**

4.1. Малын сэг, зэм устгахад шаардагдах ариутгал, халдваргүйтгэлийн бодис, шаардлагатай эм бэлдмэлийн нөөцийг яаралтай бүрдүүлэх, татан авах, орон нутагт хүргэх ажлыг зохион байгуулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах;

4.2. Малын сэг, зэм устгахад шаардагдах хүн, техник хэрэгсэл, хөрөнгө санхүүгийн тооцоолол, төлөвлөлтийг нарийвлан гаргаж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах;

4.3. Зудын улмаас үхсэн малын махыг төв суурин газрын болон бусад хүнсний хэрэглээнд нэвтрүүлэх, худалдан борлуулах, зах зээлд нийлүүлэх зэрэг хууль бус үйлдэл гарахаас урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулж, тогтмол хяналт тавьж ажиллах;

**Тав. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:**

5.1. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас аймаг, сумдын онцгой комисс, Засаг даргын тамгын газруудад өгч буй хандив тусламжийн хөрөнгийг малчдад зориулж оновчтой хуваарилах, ил тод байдлыг хангаж ажиллах;

5.2. Малчдад тусламжаар олгож буй улсын нөөцийн болон аймаг, сумдын аюулгүй нөөцийн өвс, тэжээл, хүнсний болон бусад бараа бүтээгдэхүүний хуваарилалтыг оновчтой зохион байгуулж, хяналт тавьж ажиллах;

**Зургаа. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:**

6.1. Монгол орны нийт нутаг дэвсгэрт хаваржилт хүндэрсэнтэй холбогдуулан малчид, иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, дархлааг дэмжих, болзошгүй өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллах;

Шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, танилцуулж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, хурандаа Т.Баярхүү нарт даалгах.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,  
ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ

